

Монгол Улс
НЭЗХДШ болон ТС-ийг боловсруулах хүрээнд Орхон аймгийн хувийн хэвшлийн байгууллагуудтай
хийсэн уулзалт
2017 оны 9-р сарын 8

Дэлхийн Банк Групп нь (ДБГ) Монгол Улсын хөгжлийн боломж, сорилт, тулгамдсан асуудал болон ДБГ-ээс Монгол Улсад үзүүлж болох дэмжлэгийн талаар санал бодлыг сонсох, солилцох зорилгоор 2017 оны 9 дугаар сарын 8-нд Орхон аймгийн хувийн хэвшлийн 19 байгууллагатай уулзлаа.

Хэлэлцүүлгийг дараах үндсэн гурван асуудлын хүрээнд хийлээ:

1. Таны бодлоор Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг хангахад ямар гол боломж, сорилт, бэрхшээл тулгамдаж байна вэ?
2. Таны бодлоор дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсын хөгжлийн нэн тэргүүний зорилго юу байх вэ?
3. Дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг тогтвортойгоор хангахын тулд ДБГ (Дэлхийн Банк, ОУСК, ОТХОБА) Монгол Улсад хэрхэн тусалж, дэмжлэг үзүүлэх нь зүйтэй гэж та үзэж байна вэ?

Ангилал	Оролцогчдын санал
<p style="text-align: center;">Дүн шинжилгээний талаар санал (боломж, сорилт, тулгамдсан асуудал ба ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжих арга замууд)</p>	<p>Боломж</p> <ul style="list-style-type: none"> • Тус орон нутаг нь төмрийн хүдэр, коксжих нүүрс, гангаар баялаг; эдгээр ашигт малтмалын үйлдвэрлэл, боловсруулалт нь бүс нутаг, улс орны хөгжилд хувь нэмрээ оруулна. • Эко бизнес болон тэдгээрийн экспортыг өргөжүүлэх боломжтой. Мал нь экспортонд гаргах боломжтой "сэргээгдэх" нөөц юм. Цэвэр усны борлуулалт нь бизнесийн том боломж байж болох юм. Түүнчлэн махны экспортын боломж нээлттэй байгаа боловч зохицуулалт хийж буй хүмүүс танил талдаа квотыг хуваарилаад өгчихдөг учраас үйлдвэрлэгчдэд боломж хязгаарлагдмал байна. Монгол улс газар нутгийн хэмжээ, малын тоогоороо өрсөлдөх давуу талтай боловч ядуурал яагаад хэвээрээ байгааг бодож үзэх хэрэгтэй. • Шинэ ерөнхийлөгч зарим тарифын татаасыг санал болгосон нь орон нутгийн бизнес эрхлэгчдэд эергээр нөлөөлж магадгүй. <p>Сорилтууд</p> <ul style="list-style-type: none"> • Маш өндөр хүүтэй, богино хугацаатай зээл нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд тогтмол нэг зээлээс дараагийн зээлийн хооронд л ажиллахад хүргэдэг. Санхүүгийн хүртээмжийг сайжруулахын тулд банкны салбарыг сайжруулах шаардлагатай. Шударга өрсөлдөөнийг дэмжихийн тулд олон улсын банкуудыг Монгол улсад оруулж ирж болох юм. • УИХ-ын гишүүд/эрх бүхий албан тушаалтнууд өөрсдийн бизнесийг дэмжих шийдвэр гаргадаг өнөөгийн улс төрийн орчинд хувийн хэвшилд төрийн оролцоо хэт их байна. Хувийн хэвшил эдийн засгийн хамгийн их ачааллыг үүрдэг, жишээ нь дэд бүтцийг бий болгох, ажлын байр бий болгох гэх мэт. Харин төрийн бүтээлч байдал маш сул байна. • Мал, эрдэс баялаг гэх мэт нөөцийн үр ашигтай зарцуулалтыг хангах бодлого, институт төрд дутагдаж байна. Засгийн газраар дамжуулан хийсэн хөрөнгө оруулалт нь эрх тэгш боломжийг олгодоггүй, үр ашиггүй байх хандлагатай байдаг. • Бизнесийн шинэ чиглэлийг нэвтрүүлэхийн тулд системийн өөрчлөлт хийх шаардлагатай; хүн ам цөөнтэй манай улс хэдхэн төрлийн бизнест төвлөрдөг, гэвч зах зээл багатай, боломж хязгаарлагдмал болохыг харгалзан үзэх нь зүйтэй.

	<ul style="list-style-type: none"> • Импорт орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг бодлогоор дэмждэггүй. Экспортын олон улсын түнш олоход маш хүндрэлтэй байдаг. • Төрөөс ЖДҮ-ийг татвараас чөлөөлөх замаар дэмжиж болох юм. Экспортын хувьд одоогийн гаалийн татвар хэт өндөр байна. • УБ хотын агаарын бохирдол байнгын тулгамдсан асуудал болж байна. • Малын эрүүл мэнд, мал эмнэлгийн үйлчилгээ, вакцинжуулалтын асуудлууд нь хөдөө аж ахуйн салбарын чадавхид сөргөөр нөлөөлж байна. Зах зээлийн эдийн засагт шилжихээс өмнө мал эмнэлгийн үйлчилгээг төвлөрсөн байдлаар үзүүлж байсан. ISO гэрчилгээ зэрэг олон улсын стандартад нийцэхэд тулгарч буй сорилтууд бий. • Бизнес эрхлэхийн оронд мөнгөө хадгаламжинд хийгээд илүү өгөөжтэй байж болох учраас аж ахуйн нэгжүүд ажлын байр бий болгоход шамдах хөшүүрэг байхгүй байна. Түүнчлэн цалинтай хөдөлмөр эрхлэхийн оронд нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжээр амьдардаг хүн амын томоохон бүлэг бий болсон учраас нийгмийн халамжаас хэт хамааралтай хүмүүсийн сэтгэлгээг өөрчлөх шаардлагатай. Хүмүүсийг сургаж, тодорхой мэргэжлийн ур чадвар эзэмшихэд нь туслах нь чухал байна. • Мөн цалин хөлс хэтэрхий бага учраас багш гэх мэт ур чадвартай ажиллах хүчин Өмнөд Солонгос зэрэг гадаад улс оронд богино хугацааны хөдөлмөр эрхлэхийг илүүд үзэх болжээ. Мэргэшсэн боловсон хүчин гадаадад илүү боломж бүхий ажил эрэлхийлдэг болсонтой холбоотойгоор зарим сул орон тоонд чадварлаг ажилтан авч ажиллуулах нь хялбар биш болжээ. Хувийн хэвшлийн салбарт стандарт ажлын цагийн хуваарь байхгүй тул ажилчдын ачаалал их байдаг. Түүнчлэн их дээд сургуулиуд хэтэрхий олширсон, их дээд сургууль төгсөгчид хөдөлмөрийн зах зээл дээр бэлэн байгаа ур чадвар бага шаардагдах ажилд орохыг хүсдэггүй. • Боловсролын салбарт бодлогын тогтвортой байдал үгүйлэгдэж байна. Үр дүнг нь тооцолгүйгээр хэт олон тооны хөтөлбөрийг богино хугацаанд хэрэгжүүлж байна. • Төсвийн хязгаарлагдмал байдлын улмаас сургууль / цэцэрлэгийн хүрэлцээ, нийлүүлэлт дутагдалтай зэрэг боловсролын салбарт асуудал үүсч байна. Хувийн хэвшлийнхэнд энэ орхигдсон орон зайг нөхөх боломжийг олгодоггүй. • Чанар муутай импортын хүнсний бүтээгдэхүүний улмаас эрүүл, аюулгүй амьдрах баталгаагүй болж байна.
<p>ДБГ-ийн стратеги ба түншлэлийн талаар ирүүлсэн санал</p>	<p>Салбарууд:</p> <ul style="list-style-type: none"> • Дотоодын эрэлт хэрэгцээ, худалдан авах чадвар хязгаарлагдмал байдлыг харгалзан экспортын тааламжтай нөхцлийг бүрдүүлж, боломжийг олгох. • Дэлхийд танигдах боломж бүхий нэг үйлдвэрийг стратегитайгаар хөгжүүлэх явдлыг Монгол улс дэмжих шаардлагатай. Энэ үйлдвэр нь хамгийн сүүлийн үеийн технологийг ашигласан байж болно. • Эко бүтээгдэхүүний үйлдвэрлэлд анхаарлаа хандуулах, жишээ нь. нано-нэхмэл, нялхсын хоол хүнс гэх мэт. • Үйлдвэрийг цогцоор нь (кластер) хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх; гэхдээ нийлүүлэлтийн хэлхээний үе шат тус бүрээр төрөлжсөн бизнесийг тусад нь хөгжүүлэх. • Хүний нөөцийн хөгжилд цаашид анхаарлаа хандуулж дэмжлэг үзүүлэх шаардлагатай. ДБГ бүх талаар дэмжлэгээ үргэлжлүүлэн үзүүлэх салбар бол боловсролын салбар юм. Тухайлбал хатуу дэд бүтцийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ ур чадварыг сайжруулах, чадавхжуулах, зөөлөн дэд бүтцийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

ДБГ-ийн зөвлөлдөх уулзалтуудын талаарх санал	<ul style="list-style-type: none"> Тус салбарт хэрэгжүүлсэн өмнөх үйл ажиллагааны амжилтанд тулгуурлан цаашид дэмжлэгээ үргэлжлүүлэх, тухайлбал бага насны хүүхдийн хөгжлийн цогцолбор барих асуудал ихээхэн ач холбогдолтой юм.
---	---

Уулзалтын үеэр авсан судалгааны дүн:

- Ирэх 10 жилийн хугацаанд ядуурлыг устгаж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжихийн тулд Монгол Улс аль чиглэлээр хөгжихөд голлон анхаарах ёстой вэ? (Боломжит хариултуудаас 5 хүртэлх хариултыг сонгоно уу)

— Боловсрол	16	84%
— Хувийн хэвшлийг хөгжүүлэх	13	68%
— Хүнсний аюулгүй байдал	12	63%
— Төрийн удирдлага/шинэтлэл	11	58%
— Гадаадын хөрөнгө оруулалт	10	53%
— Авилгатай тэмцэх	8	42%
— Эрүүл мэнд	7	37%
— Ажлын байр бий болгох/хөдөлмөр эрхлэлт	4	21%
— Худалдаа, экспорт	4	21%
— Ус, ариун цэврийн байгууламж	4	21%
— Эдийн засгийн өсөлт	3	16%
— Санхүүгийн зах зээл	3	16%
— Зам, тээвэр	3	16%
— Байгалийн нөөцийн удирдлага	2	11%
— Хөдөө аж ахуй, мал аж ахуй, ойн сан	2	11%
— Эрх тэгш боломжоор хангах	2	11%
— Хөдөөгийн хөгжил	1	5%
— Байгаль орчныг хамгаалах, бохирдлыг хянах	1	5%
— Эрчим хүч	1	5%
— Гамшгийн эрсдлийн удирдлага	0	0%
— Хотын хөгжил	0	0%
— Нийгмийн хамгаалал	0	0%
— Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах	0	0%
— Бусад:	0	0%

- Дараагийн 4-6 жилийн хугацаанд ДБГ Монгол Улсыг аль чиглэлд дэмжвэл хамгийн их үр дүнтэй гэж та үзэж байна вэ? (Боломжит хариултуудаас 3 хүртэлх хариултыг сонгоно уу)

— Хүний хөгжлийг дэмжих	7	37%
— Бизнесийн орчинг сайжруулах чиглэлээр дэмжих	7	37%
— Байгалийн нөөцийн удирдлага, байгаль орчныг хамгаалах чиглэлээр дэмжих	5	26%
— Төрийн удирдлага, засаглалын чиглэлээр дэмжих	3	16%

— Дэд бүцгийн хөрөнгө оруулалтыг дэмжих	3	16%
— Дээрх бүгд чухал	3	16%